ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 10 сарын 31 өдөр Дугаар 129 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл сэргээх тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2-т заасан хуулийн этгээдийн Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 3-т заасан хуулийн этгээдийн Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус сэргээсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Ч.ЗОЛБАЯР

Ө.ЗОЛБАЯР

А.ДУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн
129 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл сэргээсэн хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөр-лийн дугаар	Хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Сүн сүн экспресс ХХК	43400051	2024.06.30	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх
2	Ойрад телевиз ХХК	13000168	2026.05.28	Ховд аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх
3	Төгс цэлмүүн ХХК	12100574 11800336	2024.07.28	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх

------ oOo --------